

5 сарын цаг үеийн мэдээ

Төр захиргааны чиглэлээр:

Сумын онцгой комиссын шийдвэрээр 1 суурин, 3 хөдөлгөөнт пост ажиллуулж иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллаж байна.

Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудад хандаж 5 өргөдөл гомдол ирж шийдвэрлэгдсэн 4, Шийдвэрлэлт 80 хувьтай.

Хууль эрхзүйн сургалт, сурталчилгааны хагас жилийн бичмэл тайланг Хууль эрхзүйн хэлтэст хүргүүлэв.

СӨБ-ийн чиглэлээр:

Зуны амралт эхэлж байгаатай холбогдуулан хүүхэд эцэг эхчүүдэд “Таньд хүргэх ил захидал”-ыг хүргэсэн. Хандалтын тоо - 82.

Бүлгийн багш нар хүүхдийнхээ насны онцлогт тохирсон цахим хичээлийг бүлгийн группээр дамжуулан зааж хүүхдэд хүргэлээ. Нийт 4 хичээлийн хандалт- 87 байна.

Туслах багш нар “Гутал үдэх, бие эрхтэн, хувцас эвхэх, амаа зайлах, маскаа зүүх дадал хэвшлүүд дадал хэвшил”-ээр цахим контентыг бэлтгэж хүргэсэн.

Ерөнхий боловсролын чиглэлээр:

Бага дундын ЗАН-ийн багш нар хамтран 1,2-р багийн нутгаар суурь тойрч сурагчдын теле болон цахим хичээл, багшийн өгсөн даалгаврын сан, тараах материалын үр дүнтэй танилцаж заавар зөвлөгөө өгч ажилласан. Нийт 107/бага анги-80, дунд анги-27/ сурагчдын теле хичээлийн тэмдэглэлийг шалгаж зөвлөгөө өгсөн.

Насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулсан “Угийн бичиг”-ийн цахим сургалтанд нийт 18 багш,ажилтан хамрагдсан.

“Зуныг зугаатай өнгөрүүлцгээе” зуны даалгаврын хүүхэд хамгааллын зөвлөмжийг бэлтгэн эцэг эх, асран хамгаалагч нарт нийт 150ш гаргаж хүргүүлсэн.

"Байгальдаа ээлтэй хандъя" чэлленжид төрийн албан хаагчид болон сургуулийн сурагчид, анги хамт олон байгаль эхээ хайрлан хамгаалах үйлст нэгдэж сумаа хоггүй сум болгох нөлөөллийн сайн үйлсийг үргэлжлүүлэн ажиллуулж байна.

Мал эмнэлгийн чиглэлээр:

2-р багийн хуц-228, ухна-90 нийт 318, 1-р багийн хуц-140, ухна-56 нийт 196 хээлтүүлэгчид үзлэг хийж ангилсан.

Ариутгал халваргүйтгэл хийсэн талбайн хэмжээ-149520м²

Санхүү, төрийн сангийн чиглэлээр:

Төсвийн хуваарийн дагуу зарлагын гүйлгээг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж гүйлгээг баталгаажуулсан.

Төсөвт байгууллагуудын 4 сарын гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд хянаж, өрийн мэдээг хүлээн авч баталгаажуулсан. Шилэн дансны сар бүрийн мэдээллийг 5 сарын 8-нд хуулийн хугацаанд мэдээлсэн.

Газрын харилцаа чиглэлээр:

2021.03.23-ны өдрийн А/22 тоот захирамжаар 7 байршилд газрын дуудлага худалдааг зарлан цахим биржид зураг, байршил зарыг оруулж, 6 байршилд оролцогч бүрдэн хугацаандаа амжилттай зохион байгуулагдан хаалаа.

2021 оны 4сарын 29-ны А/36 тоот захирамжаар Худалдаа үйлчилгээний газар,төв цогцолбор зориулалтаар 1 байршилд газрын дуудлага худалдааг дахин зарлаж цахим биржээр дуудлага худалдаа явагдлаа.

Нийт дуудлага худалдааны төлбөрийн орлого 8.090.000 төгрөгийг төрийн сангийн холбогдох данснуудад төвлөрүүлсэн болно.

Дуудлага худалдаагаар газар эзэмших иргэний- 5, шинээр газар эзэмших-3 , өргөдлийн дагуу эзэмших -2 ,өргөдлийг тус тус хүлээн авч бүртгэн 5 өргөдлийг засаг даргын захирамжийн төсөл төлөвт шилжүүлээд байна.

3 иргэний газар өмчлөх, 2 иргэний үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авах захиалгыг хүлээн авлаа.

Байгаль орчны чиглэлээр:

Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд иргэд ААН, албан байгууллага, иргэдээс 6 төрлийн модны 320 ширхэг суулгацны захиалга авч сумын хэмжээнд 350ш мод тарьлаа.

Бүх нийтийн их цэвэрлэгээнд 5 албан байгууллага, 100 гаруй иргэд хамрагдаж 100 га талбайгаас 2 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.

12 золбин нохойг устгалаа.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аяны хүрээнд:

“КОВИД-19” өвчнөөс урьдчилан сэргийлэх 3 төрлийн зөвлөмжүүдийг албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн мэдээллийн самбарт байршуулсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай ойлголт, хуулийн талаарх сургалтыг 5 байгууллагын 85 албан хаагчдад зохион байгууллаа.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хийж хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрт хамрагдахаар төслөө өгсөн 6 иргэний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

5 дугаар сарын 20-ны байдлаар 94 хүнд 14 чиглэлээр мэдээлэл өгч ажилласан байна.

Соёл урлагийн чиглэлээр:

Аймгийн ахмадын хорооноос зохион явуулж буй цахим дууны тэмцээнд сумын ахмадын хороотой хамтран 6 ахмадуудыг бэлтгэн оролцууллаа.

НАРАН СУМ СОЁЛЫН ТӨВ фэйсбүүк групп дээр өөрийн номын санд байгаа номуудаас хэсэгчлэн оруулж уншигч үйлчлүүлэгчид үйлчилж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үндсэн үзүүлэлтүүд:

- Нийт үзлэг-183
- Амбулаторийн үзлэг-38
- Гэрийн идэвхитэй хяналт-19
- Урьдчилан сэргийлэх-95
- Артерийн гипертензин эрт илрүүлэг-27
- Чихрийн шижин эрт илрүүлэг-27

- Жирэмсний хяналтанд хамрагдсан-29
- Жинэлсэн хүүхдийн тоо-23
- Эмнэлэгт хэвтсэн-9
- Холын дуудлага-15
- Төвийн дуудлага-36

Сэргээн засах:

Нийт -8 иргэнд

1. Нил улаан туяа -7 /том хүнд/
2. Бумба-4 /том хүн//
3. УВЧ-1 /хүүхэд/
4. Зөөлөн иллэг-7 /том хүнд/ /
5. 0-2 насны 32 хүүхдэд товллын дархлаажуулалт хийсэн.

Асаргаа үйлчилгээ

- Үйлчлүүлэгчийн толгой угаасан -2 иргэн
- Хэсэгчилсэн угаалга-3
- Цагаан хэрэглэл сольсон-11

Эмчилгээний хоолны сургалт- 6, Хүүхдийн хоолны сургалт-1 хүүхэд хамрагдсан.

Аюултай хог хаягдлыг цэгийг шинээр байгуулсан.

15 ахмад настанд эрийн эргэлт, усны 2 машинд ариутгал халдваргүйтгэл хийсэн.

“Ковид-19” өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Нийт-1121 хамрагдахаас төрийн албан хаагчид 1,2-р тунг 100%, 50-аас дээш насны ахмадууд болон 18-49 насныханд 1-р тунд нийт-945 иргэнийг вакцинжуулсан.

Голомттой бүсээс ирсэн иргэдийг гэрийн ажиглалтанд авч тандалт хийж, 11 машиныг ариутгаж халдваргүйжүүлсэн.

Хөдөөгийн 20 айлаар 2 төрлийн 40ш зөвлөмж тарааж,мэдээ мэдээлэл хүргэсэн.